БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД

“ХӨНГӨН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР (LRT) ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨВ” БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 01 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

1. Төслийн нэр:

Хөнгөн төмөр замын тээвэр (LRT) төсөл

2. Төслийн зорилго:

Улаанбаатар хотын нийтийн тээвэрт орчин үеийн тээврийн дэвшилтэт технологийн цогц систем бүхий шинэ төрлийн хөнгөн төмөр замын тээврийг нэвтрүүлэн хөгжүүлэх, авто замын ачааллыг бууруулж хүрээлэн буй орчны тогтвортой байдал, агаар орчны бохирдлыг бууруулах, түүнчлэн Улаанбаатар хот орчмын дагуул хотуудын эдийн засгийг хөгжүүлэх замаар шинэ суурьшлын бүсүүдийг холбоход оршино.

3. Үндэслэл

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын Зам, тээврийн сайд (ТЕЗ)-ын XV.1.4.7.2-т батлагдсан “Хөнгөн төмөр замын тээвэр (LRT) төслийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил, Засгийн газрын 2024 оны 238 тогтоол, Засгийн газрын 2024 оны 22 дугаар хуралдааны тэмдэглэл.

4. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын хүн ам 2023 оны байдлаар 3.5 сая хүрч өссөн бөгөөд, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 6’008 ам.долларт хүрээд байна. Азийн хөгжлийн банкны “Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв[1]” баримт бичигт “Монгол Улсын газар зүйн байршил, байгалийн арвин баялаг нь тус улсын хөгжлийн үр дүнг

[1] “Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв” Хоёр том гүрний дунд орших арвин баялаг бүхий орон Маттиас Хэлба, Хал Хилл, Деклан Магий 2020 он

тодорхойлдог. Хүн амын нягтралаараа дэлхийн хамгийн багад тооцогддог тул байгалийн баялагт түшиглэсэн үйл ажиллагаа явуулахад харьцангуй хүчтэй давуу талтай байх боломжтой. Монгол Улсын эдийн засаг нь нийслэл хот болон уул уурхайн салбарт төвлөрсөн ер бусын бүтэцтэй бөгөөд тэдгээр нь дотоодын нийт бүтээгдэхүүн 65 хувь, 20 хувийг тус тус эзэлдэг нь Ойрх Дорнодыг эс тооцвол дэлхийн хамгийн өндөр экспортын төвлөрөл (бүтээгдэхүүн болон хүлээн авагч зах зээлийн хувьд)-тэй улс юм" гэж тодорхойлжээ. Монгол Улсын эдийн засаг нь 2024 оны эхний хагаст уул уурхайн салбар 15.4 хувиар, уул уурхайн экспортын тээвэр, бараа бүтээгдэхүүний импорт, дамжин өнгөрөх тээвэр нэмэгдсэнээр тээврийн салбар 27.4 хувиар, аж үйлдвэр болон барилгын салбар 7.9 хувиар, худалдаа, үйлчилгээний салбарууд (тээврээс бусад) 7.8 хувиар тус тус тэлсэн байна[2].

5. Төслийн хэрэгцээ шаардлага

Улаанбаатар хотын хүн ам 1990 онд 590,600 байсан бол 2020 онд 1,597,300 болж сүүлийн 30 жилийн хугацаанд 3 дахин өсөж, нийслэл хотын хүн амын нийт хүн амд эзлэх хувь 1990 онд 27.2 хувь байсан бол 2020 оны байдлаар 47.6 хувь болж өссөн.

Хотын нийт хүн амын 95.2 хувь буюу 1426.6 мянган хүн төвийн 6 дүүрэгт байнгын, 120 гаруй мянган хүн түр оршин сууж, 2023 онд 1.7 сая хүн амтай болсон нь 2040 он гэхэд 2.2 сая болж өсөх төлөвтэй байна. Түүнчлэн манай улсын хүн ам сүүлийн 20 жилийн хугацаанд жилд дунджаар 1.3 хувь өссөн байхад Улаанбаатар хотын хүн ам дунджаар 3.3 хувиар өссөн ба хотын хүн амын өсөлтийн нэлээд хувийг хот руу ирж буй шилжилт хөдөлгөөн эзэлж, цаашид ч төвлөрөл буурахгүй, хүн амын өсөлт эрчимтэй үргэлжлэх хандлагатай байгаа нь тус хотод шилжин ирж болон явж байгаа хүн амын харьцаа, хүн амын нягтралын үзүүлэлтийн өсөлтөөс тодорхой харагдаж байна. Хотын хүн амын өсөлт, хотжилт, түүнийг дагасан тээврийн хэрэгслийн тоо, хотын тэлэлт зэргээс шалтгаалан Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл сүүлийн жилүүдэд үлэмж нэмэгдсээр байна.

Улаанбаатар хотын дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2023 оны байдлаар 46,9 их наяд төгрөгт хүрч, Монгол Улсын ДНБ-ний 66.5 хувийг эзэлж байгаа нь 2013 оны үзүүлэлттэй харьцуулахад 12,2 их наяд төгрөг буюу ойролцоогоор 4 дахин өссөн үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотын эдийн засгийг бүрдүүлэгч салбар нь үйлчилгээ 58.2 хувь, үйлдвэрлэл 41.1 хувь, хөдөө аж ахуй 0.5 хувь байна. Тус нөхцөл байдал нь 2040 онд хэвээр хадгалах төлөвтэй байна[3]. Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, иргэдийн эрүүл, тав тухтай орчныг бүрдүүлэх бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгоход анхаарч олон улсаас хөрөнгө оруулалт татах, хууль, эрх зүйн орчин бүрдүүлэхэд чиглэн ажиллаж байна. Үүний хүрээнд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдаж, нийслэлд бонд гаргах эрхийг олгосноор олон улсад ашигладаг санхүүжилтийн аргачлалыг ашиглаж эхлэх боломжтой болсон. Олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний Фитч агентлаг 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний "B" төлвийг "B+" болгосныг зарласнаар системийн нөлөө бүхий

[2] Монгол Улсын Эдийн засаг хөгжлийн яам цахим хуудас
[3] Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепц, 2020 он

ЭХ ХУВЬ
2025 04

дотоодын зарим банкны зээлжих зэрэглэл мөн адил өссөн. Сүүлийн 10 жилд анх удаа болж буй энэхүү шинэчлэл нь Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлт сайжирч, төсвийн менежментийн оновчтой байдлыг харуулж байна.

Улсын хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар нийт 1.312.000 бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэл байгаагийн 785.500 буюу 59,8 хувь нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна.

Улаанбаатар хотын авто замын сүлжээний урт 1213 км байгаагийн 75 хувь нь барилгажсан нутаг дэвсгэр, 25 хувь нь гэр суурьшлын бүсэд байрлах бөгөөд 2020 онтой харьцуулахад авто замын сүлжээ нь 433.8 км буюу 35.8 хувиар нэмэгдсэн байна. Улаанбаатар хотын авто замын ачааллын өнөөгийн нөхцөлийн загварчлалын үр дүнгээр 2023 оны хэмжээнд өдрийн турш түгжрэлтэй байх авто замын сүлжээний урт нь 97.3 км, авто замын сүлжээний оргил цагийн хурд 7-13 км/ц болж хотын нийт зорчих хөдөлгөөнд нийтийн тээвэр 39.8 хувь эзэлж байгаа бөгөөд цаашид авто замын түгжрэлийг бууруулах чиглэлд тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэхгүй байх тохиолдолд 2030 оны түвшинд өдрийн турш түгжрэлтэй байх авто замын сүлжээний урт нь 200км-т хүрч, авто замын сүлжээний оргил цагийн хурд 5 км/ц болж, хотын нийт зорчилтын нийтийн тээврийн эзлэх хувь 25 хувь болон багассанаар “Улаанбаатар хотын авто замын сүлжээ зогсолт”-д орох эрсдэл үүсэхийг тодорхойлсон[4]. Дээрхийг үндэслэн Улаанбаатар хотод авто замын сүлжээний бүтцийг сайжруулах, нийтийн тээврийг хөгжүүлэх буюу тээвэрт суурилсан хөгжүүлэлт хийх чиглэлд урт, дунд хугацааны бодлого хэрэгжүүлж байна.

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06 өдрийн 143 дугаарын тогтоолоор Шинэ зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан. Мөн Шинэ зуунмод хотын эрх зүйн байдлын тухай тухай хууль 2024 оны 6 дугаар сарын 05 өдөр тус тус батлагдсан байдаг.

Шинэ зуун мод хотыг Улаанбаатар хоттой холбох тээврийн оновчтой, үр ашигтай, зорчих хугацааг хэмнэх цогц систем хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь дагуул хотыг хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засгийн өсөлт болон иргэдийг төвлөрлөөс зайлсхийх, амьдрах чанар, тав тухтай байдлыг сайжруулах ач холбогдолтой.

Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд дагуул хотыг хөгжүүлэхээр тусгасан бөгөөд дагуул хот тус бүрийн төлөвлөлтийг боловсруулсан байна. Гэвч тухайн төлөвлөлтийг боловсруулан баталсан 2013 оноос хойш Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хүн ам 210,000 хүнээр нэмэгдсэн бол дагалдах бусад хот суурин тухайлбал хөрөнгө оруулалт харьцангуй их хийгддэг алслагдсан 3 дүүрэгт гэхэд ердөө 1.1 дахин өссөн. Улсын төсөв хязгаарлагдмал тул дагуул хотыг хөгжүүлэх ялангуяа тухайн хот руу хүн ам, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг нүүлгэн суурьшуулах ажлыг эрчимжүүлэхийн тулд сонголтыг зөв хийх, нэг төлөвлөгөөнд төвлөрч, дагуул хотуудыг шат дараатайгаар бүтээн байгуулах шаардлагатай.[5]

---

[4] Жайка судалгаа

[5] Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгаа Эцсийн тайлан

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
2025 04

Дагуул хотуудын хамгийн түрүүнд шийдвэрлэх асуудал нь үндсэн хоттойгоо холбогдох нийтийн тээвэр байдаг ба нийтийн тээврээр холбогдохгүйгээр дагуул хотуудыг хөгжүүлэх боломжгүй юм. Чингис хаан олон улсын нисэх буудлаас Улаанбаатар хоттой холбох нийтийн тээврийн хязгаарлагдмал байдал, хотын төвийн авто замын түгжрэлээс шалтгаалан ирж очиход маш их цаг хугацаа зарцуулж байгаа нь хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж улмаар шинэ суурьшлын бүс байгуулах, дагуул хотуудын эдийн засгийн таталцал үүсгэх гол хөшүүрэг болох ажлын байруудыг олноор бий болгох, иргэдийн аятай тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд ихээхэн хүндрэлийг учруулж байгаа билээ .

Шинэ зуунмод хот нь 150,000, Майдар хот нь 40,000 буюу одоогийн Төв аймгийн Сэргэлэн сумын төвийн хүн амаас 7 дахин их хүн амтай хотыг байгуулахаар тооцоологдсон бөгөөд Нийслэлийн дагуул хот болгон хөгжүүлэхийн тулд шийдвэрлэхийн тулд дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:

Шинэ зуунмод хотын хүн амыг нэмэгдүүлэхэд Улаанбаатар хотоос шилжин ирэгсдийг татах гол хөшүүрэг бол их багтаамжийн нийтийн тээврээр дагуул хотыг нийслэл хоттой холбох, Улаанбаатар хотоос хамгийн дөт боломжит авто замаар дагуул хоттой холбох нь нэн тэргүүний ажил юм.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Хөшигийн хөндийн туннел, Өөдөө тэмүүлэх Монгол, олон улсын стандарт шаардлага хангасан нийтийн тээврийн их багтаамжийн хөнгөн төмөр замын (LRT) тээврийн барьж байгуулахаар шийдвэрлэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын Зам, тээврийн сайдын (ТЕЗ)-ын XV.1.4.7.2, XV.1.4.6, XV.2.4.-д тус тус улсын төсвийн хөрөнгө оруулалтыг тусгасан.

Дээрх төсөл хөтөлбөрүүд нь Улаанбаатар хотын төвлөрөлийг задлах, авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд төлөвлөгдөж байгаа цогц арга хэмжээнүүд бөгөөд Улаанбаатар хотын хойд хэсгээс сэлбэ гол дагуу хийгдэх 27км урт хурдны авто замаас Өөдөө тэмүүлэх Монгол ган татлага бүхий гүүрэн байгууламжаар Туул хурдны зам дээгүүр Хөшигийн хөндийн туннелээр дамжин одоогийн Зуунмод хот, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал, Шинэ зуунмод хот хүрнэ. Энэхүү ган татлага бүхий гүүрэн байгууламж нь Нийслэл хотод хэрэгжүүлэх Туул хурдны зам, Шинэ тойрог авто зам болон бусад дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдтэй нягт уялдаатай байх бөгөөд Их Монгол улсын гудамжнаас Төв аймгийн Зуун мод хот хүртэл 14 орчим минут Шинэ зуун мод хот хүртэл 30 орчим минут зорчих бол Нийтийн тээврийн их багтаамжийн хөнгөн галт тэрэг нь Улаанбаатар метро төслийн баруун чиглэлийн эцсийн өртөө болох Энхжин худалдааны төв орчмоос урагш Буянт-Ухаа, Өлзийт тосгоноор дайран өнгөрч Чингис хаан олон улсын нисэх хүртэл 36.8 км хөнгөн төмөр замаар холбогдон Шинэ зуунмод хот хүрэх юм.

Дээрх төслүүд нь Улаанбаатар хот-Шинэ зуунмод хотуудыг ган татлагат гүүрэн байгууламж, 15.8 км туннел бүхий авто зам, шинэ төрлийн нийтийн тээврийн хөнгөн галт тэргээр холбож дэд бүтцийн шинэ холболтыг бий болгож эдийн засгийн

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 04

харилцан таталцал, иргэдийн шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлэх онцгой ач холбогдолтой нэгдсэн цогц төсөл арга хэмжээ юм.

6. Төслийн үзэл баримтлал

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэл хотод олон улсын стандарт хангасан хөнгөн төмөр замын тээвэр (LRT) барьж байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулна.

7. Төслийн ажлын хамрах хүрээ:

Энэхүү ажлын даалгаврын хүрээнд Улаанбаатар хотын Богд уулыг тойрсон хөнгөн төмөр замын тээврийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулна.

Тайлбар: Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30."**зураг төсөл**" гэж "барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг" гэж заасан.

7.1. "Толгойт-"Буянт-Ухаа"-Өлзийт-"Шинэ Зуунмод хот"-Зуунмод-Майдар-Налайх-Амгалан" чиглэлийн хөнгөн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах;

7.2. "Толгойт-"Буянт-Ухаа"-Өлзийт-"Шинэ Зуунмод хот"-Зуунмод-Майдар-Налайх-Амгалан" чиглэлийн хөнгөн төмөр замын зураг төсөл боловсруулах;

7.3. Чигийг техник, эдийн засгийн үндэслэлээр нарийвчлан тогтоох;

7.4. Техник эдийн засгийн үндэслэлд хөнгөн галт тэрэгний чигийг тогтоохдоо улсын тусгай хамгаалалттай газрын хориглолт, хязгаарын бүстэй давхцуулахгүйгээр төлөвлөх, зэрлэг амьтадын нүүдэл шилжилт хөдөлгөөний нарийвчилсан судалгааг хийж нүхэн болон гүүрэн гарцыг төлөвлөх.

8. Хууль, бодлогын баримт бичиг төсөл хөтөлбөр стандарт, норм

Монгол Улсын хуулиуд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
- Төмөр замын тээврийн тухай хууль
- Авто замын тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль;
- Газрын тухай хууль;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 04 дугаар тушаал

- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;

- Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль

- Геодези, зураг зүйн тухай хууль

- Газрын хэвлийн тухай хууль;

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль;

- Зөвшөөрлийн тухай хууль;

- Зөрчлийн тухай хууль;

- Усны тухай хууль;

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль

- Соёлын өвийг хамгаалах тухай хууль

- Эрчим хүчний тухай хууль

- Харилцаа холбооны тухай хууль

- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;

- Тусгай хамгаалалтын газар нутгийн орчны бүсийн тухай;

- Гамшгаас хамгаалах тухай хууль;

- Галын аюулгүй байдлын тухай хууль;

- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;

- Барилгын тухай хууль;

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай;

- бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг

9. Төсөлтэй уялдуулах бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүд:

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;

- "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр";

- Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичиг;

- “Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний /концепц/ үзэл баримтлал”;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нууцын бичгийн
даргын 2025 04 дугаар тушаал

- “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;

- Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Номтын ам дахь Засаг, захиргааны цогцолборын төлөвлөлт;

- Хүннү хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

- Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө;

- Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын далан, сувгийн өндөржилтийн нэгдсэн зураг төсөл;

- “Шинэ тойрог зам” төсөл;

- Их багтаамжийн метро;

- BRT тусгай замын автобусны төсөл;

- Аялал, жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр;

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй холбогдох бусад төсөл, хөтөлбөрүүд;

- Төмөр зам ба авто замын тоннель (БНбД 32-05-07)

- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-01-04);

- Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар (БНбД 30-103-20);

- Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09);

- Барилгын орчны тохижилтын ажил (БНбД 3.01.06-90);

- Тохижилт, бусад ажил (БНБД 81-59-05);

- Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам (БНбД 33-01-03);

- Голын гидротехникийн барилга байгууламж (БНбД 33-03- 05);

- Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм (БНбД 2.01.14-86);

- Усны барилга байгууламжийн буурь (БНбД 33-04-09);

- Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц (БНбД 33-06-09);

- Шороон боомт /БНбД 33-07-09);

- Хот суурины гудамж, зам төлөвлөлт (БНбД 32-01-04);

- Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-102-07);

- Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ (БД 81-106-16);

- Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал (БНбД 21-01-02);

- Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм (БД 43-101-03);

- Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил (БД 11- 105-19)-ыг үндэслэн байр зүйн зургийн тодруулалт хийсэн дэвсгэр зураг ашиглах;

- Холбооны кабелийн суурилуулалт, ерөнхий шаардлага /MNS4908:2022/;

- Холбооны кабель шугамын ажлын зураг төсөв хийх стандарт /MNS 5596:2020/;

- Мэдээлэл холбооны сүлжээний гадна холбооны зургийн тэмдэглэгээ /MNS 4908:2022/;

- Шилэн кабель угсралт суурилуулалтын стандарт /MNS 5217:2011/;

- Холбооны кабель шугамыг авто зам, төмөр замыг хөндлөн гарах болон гүүрний байгууламжаар дамжуулан суурилуулахад тавих ерөнхий шаардлага /MNS 6597:2021/;

- Барилгын инженер-геологи, геотехникийн судалгааны ажил (БНбД 11-03-21);

- Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл /БНбД 11-07-19/ барилгын норм, дүрэм;

- "Барилга байгууламжийн геодезийн ажил" /БНбД 11-08-23/ барилгын норм, дүрэм;

- "Агаар, сансрын зураглалын ажил" /БНбД 11-14-23/ барилгын норм, дүрэм;

- "1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил" /БД 11-106-08/;

- Авто зам болон төмөр замын геодезийн ажил /БД 11-114-14/ барилгын дүрэм;

- Монгол Улсын өндрийн I ба II ангийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм /БНбД 11-09-16/;

- Өндрийн I, II ангийн сүлжээний тэгшитгэн бодолтын ажил /БНбД 11-107-16/;

- Ус, дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодезийн ажил /БД 11-115-16/;

- Эрчим хүч, харилцаа холбооны инженерийн байгууламжийн геодезийн ажил /БД 11-120-17/;

- Өндрийн III ба IY ангийн сүлжээ байгуулах /БД 11-121-19/ барилгын дүрэм;

- Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил /БД 11-104-19/;

- Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ /БД 81-103-21/;

- Нисгэгчгүй нисэх төхөөрөмж, агаарын зураглал ба газрын зураг гүйцэтгэх ажил /БД 11-124-21/

- Геодези, зураг зүйн үйлдвэрлэлд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм /БНбД 11-12-22/;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 оны 04 дүгээр тушаал

- “1:10 000, 1:25 000, 1:50 000, 1:100 000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил /БД 11-124-21/;

- Навигацийн хиймэл дагуул (GNSS)-ийн технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах дүрэм /БНбД 11-13-22/;

- “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил” /БД 11-104-06/ барилгын дүрэм;

- “Хот байгуулалтын кадастер” /БНбД14-01-07/;

- “Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох” /БНбД 50-01-16/ норм, дүрэм;

- “Өндөр барилга байгууламжийн хэв гажилтыг тодорхойлох, үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмж суурилуулах, үеийн геодезийн хэмжилт” /БД 11-118-17/;

- “Өндөр барилгын төлөвлөлт” /БНбД 31- 17- 10/;

- “Инженерно-геологические изыскания для стройтельства”, /СП 11-105-97/, Часть I. Общие правила приозводства работ ;

- Өндөр барилгын геотехникийн судалгааны дүрэм (Specification for geotechnical investigation of tall buildings JGJ 72-2004) БНХАУ;

- MNS 3263:2014 Хөрсний ангилал;

- MNS 3757-3:2013 Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага;

- MNS 3672:84 Хөрс. Барилга байгууламжийн хээрийн хэв гажилтыг хэмжих аргууд;

- Өндөржилт төлөвлөлтийн гарын авлага /Архитекторуудад зориулсан/, 2023 он.

- Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж (БНбДЗ.05.04-90);

- Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил (БД 11- 105-19)-ыг үндэслэн байр зүйн зургийн тодруулалт хийсэн дэвсгэр зураг ашиглах;

- Барилгын инженер-геологи, геотехникийн судалгааны ажил (БНбД 11-03-21);

- Инженер-геологийн судалгааны ажлын тайлан, дүгнэлт бичих дүрэм (БД-11-107-11);

- MNS 6925-9:2021 Газар зүйн мэдээлэл. Инженер- геологийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт;

- Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага (МЫ8 6055 : 2009);

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 04 дугаар тушаал

- Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага (МЫ8 5682 : 2006);

- Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар (MNS 6056 : 2009);

- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ (MN№ 5973 :2009);

- Бетонон суваг, үерийн ус зайлуулах хоолой. Техникийн шаардлага (MNS AASHTO M89 M:2005);

- ММ8 6702:2017 Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт "Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000";

- Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж (БНбД 40-02- 06);

- MNS 3237:1989 Ерөнхий төлөвлөгөө. Зам тээврийн таних тэмдэг, дүрслэл;

- MNS 5873:2008 Барилгын зураг. Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн таних тэмдэглэгээ;

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А- 230/217 дугаар журам;

- Үндэсний хөгжлийн газрын даргын 2020 оны А/56 дугаар тушаалаар батлсан "Төслийн техник эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх аргачлал";

- Бусад хот төлөвлөлт, зам, гүүр, усны барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тохижилтын зураг төсөл боловсруулахад мөрдөж буй хүчин төгөлдөр норматив баримт бичиг, дүрэм, журам;

- "Хот тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх" БД 30-102-11;

- "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04;

- "Хот суурины гудамж зам төлөвлөлт" БНбД 32-01-04;

- "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" 22.01.01/2006;

- "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04;

- "Геодезийн ажил" БНбД 3.01.03-88;

- "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норматив" БД 31-101-04;

- "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009;

- Тал хээр, говь цөлийн бүсийн авто зам болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц төлөвлөх MNS 6515:2015;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 04 дугаар тушаал

- Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага MNS 6735:2018;

- Монгол улсын Цахилгаан байгууламжийн дүрэм;

- Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм;

- Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм;

- Монгол Улсын бусад стандарт, дүрэм журмууд.

Бүх холбогдох дүрэм журам зураг төслийн стандартыг хамгийн сүүлийн үеийн өгөгдөлд үндэслэн хэрэглэх бөгөөд тусгайлан заагаагүй тохиолдолд захиалагч талтай зөвшилцөж хэрэглэнэ.

10. Техникийн судалгаа, шинжилгээ.

10.1. Хөнгөн галт тэрэгний техник технологи, хөдлөх бүрэлдэхүүн, зам, тоног төхөөрөмж, зогсоол, буудлуудын дэд бүтэц, зохион байгуулалтыг олон улсын стандарт болон Монгол Улсын нөхцөлд тохируулсан байх.

10.2. Замын хэвгийн хамгийн их байх нөхцөлийг тодорхойлон, зорчигчдод ая тухтай, намуун зөөлөн байлгах шаардлагыг хангуулсан байх.

10.3. Геодезийн судалгааны ажлуудыг дараах байдлаар оруулах. Үүнд:

10.3.1. Агаарын сансрын зураглал 1:1000-2000 масштабтай;

10.3.2. Байр зүйн зураглал 1:500 масштабтай нарийвчилсан;

10.3.3. Өндрийн хэмжилт;

10.3.4. Байр зүйн өндрийн болон байршлын геодезийн сүлжээ байгуулах /I-II ангийн сүлжээ/;

10.3.5. Инженер геодезийн зураглал 500-1000 м өргөнд зурваст хэмжилтийг хийх;

10.4. Олон нийтийн оролцоо болон төслийн ойлголтын тухай суурь судалгаа хийх;

10.5. Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, түүний зохион байгуулалт, шийдвэрийн баримт бичиг боловсруулах;

10.6. Тухайн нутаг дэвсгэрт төмөр зам баригдсанаар дэд бүтэц, иргэд болон мал, ан амьтад явах нөхцөлд хэрхэн нөлөөлөх талаар орон зайн судалгаа хийх;

10.7. Гадаад болон дотоодын ажиллах хүчний тооцоо, судалгааг хийх.

11. Техник, эдийн засгийн үндэслэлд дараах зүйлсийг агуулсан байна.

Энэхүү ажлын даалгаварт дурдсанаас бусад шаардлагатай тооцоо судалгааг төслийн онцлогоос хамааруулан гүйцэтгэх бөгөөд техник, эдийн засгийн үндэслэлийн тайлан нь доорх заалтуудаар хязгаарлагдахгүй болно.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн албаны бичгийн
даргын 2025 04 дугаар тушаал

11.1. *Инженерийн судалгаа, тайлан*

11.1.1. Төслийг хэрэгжүүлэх эрх зүйн орчны судалгаа;

11.1.2. Төлөвлөж буй шугамыг 2-оос цөөнгүй хувилбар боловсруулж, харьцуулалт гаргах;

11.1.3. Санал болгож буй шугамын зорчигч урсгалын тооцоолол;

11.1.4. Газар дээрх болон доорх инженерийн байгууламжийн нарийвчилсан судалгаа;

11.1.5. Чигийн дагуу геодезийн хатуу цэгүүдийн байршлын мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч уялдуулах устахаас сэргийлэх, зайлшгүй нөлөөлөлд өртөх бол нүүлгэн шилжүүлэлт, шаардагдах зардлын хэмжээг тооцох;

11.1.6. Инженер геодезийн судалгаа;

11.1.7. Ус зүйн, гидрогеологи судалгаа;

11.1.8. Геотехникийн судалгаа;

11.1.9. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ;

11.1.10. Байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ;

11.1.11. Археологи, палеонтологийн судалгаа;

11.1.12. Угсаатан зүйн судалгаа;

11.1.13. Бичил уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээ;

11.1.14. Газар хөдлөл чичирхийллийн судалгаа;

11.1.15. Барилгын материал хайгуул судалгаа;

11.1.16. Газар ашиглалтын судалгаа;

11.1.17. Хөнгөн төмөр замын трассын дагуу халиа тошин болон цэвдгийн тархалтыг нарийвчлан судалж, цэвдгийн алдрал, хөнгөн төмөр замын инженерийн байгууламжид үзүүлэх нөлөөг багасгах байгальд ээлтэй инженер технологийн шийдлийг тусгах;

11.1.18. Уур амьсгалын хүчин зүйлсийн нөхцөл нөлөөлөл, онцлог, даван гарах арга зам.

11.2. *Төлөвлөлт*

11.2.1. Хөнгөн төмөр замын буудлуудын барилга, байгууламжийн ерөнхий төлөвлөгөө, барилгын дотор зохион байгуулалтын төлөвлөлт, хөдөлгөөн зохион байгуулалтын төвийн төлөвлөлт;

11.2.2.Төслийн маршрутын боломжит хувилбаруудад буудал, зогсоол, засварын байршлуудыг тодорхойлж орчны нөхцөлд нийцүүлэн төлөвлөх

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 04 дүгээр тушаал

11.2.3.Хөнгөн төмөр замын тээврийн хөдөлгөөн зохион байгуулалтын шийдэл, шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний төрөл, тоо, хүчин чадлын тооцоо, зурмаг болон эргэлтийн тооцоо;

11.2.4.Хөдлөх бүрэлдэхүүний засвар болон ашиглалтын депо, аж ахуйн байгууламжийн шийдэл /хөдлөх бүрэлдэхүүний зогсоолын зам талбай гэх мэт/;

11.2.5.Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын систем болон мэдээлэл харилцаа холбооны системийн шийдэл;

11.2.6.Эрчим хүч болон цахилгаан хангамжийн байгууламжийн шийдэл;

11.2.7.Ус хангамж, ариутгах байгууламжийн төслийн шийдэл;

11.2.8.Ус зайлуулах, өнгөрүүлэх байгууламжийн шийдэл;

11.2.9.Хүний нөөцийн төлөвлөлт;

11.2.10.Гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөө /гал түймэр, үер, газар хөдлөлт, байгалийн бусад давагдашгүй хүчин зүйл/;

11.2.11.Бүс нутагт ашиглагдаж байгаа болон барихаар төлөвлөгдөж буй бусад дэд бүтцийн инженерийн байгууламжуудтай /авто зам, төмөр зам, эрчим хүч, дулаан, шилэн кабель гэх мэт/ огтлолцох хэсгийн төлөвлөлт, шийдэл;

11.2.12.Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа;

11.2.13.Хөнгөн төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга замын стратеги төлөвлөлт боловсруулах;

11.2.14.Барилга угсралтын ажлын тоо хэмжээ;

11.2.15.Төсвийн тооцоо;

11.2.16.Барилга угсралтын ажлын аргачлал, барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг төсөл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө;

11.2.17.Хөнгөн төмөр замын тээврийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулах, засвар, үйлчилгээний төлөвлөлт, зохион байгуулалт;

11.2.18.Шугамын дагуу одоо байгаа барилга, байгууламж, газар доорх байгууламж, түүнийг зайлуулах нүүлгэн шилжүүлэх шийдэл, төлөвлөлт;

11.2.19. Монгол Улсын болон Олон Улсын Цахилгаан техникийн хорооноос /IEC/ гаргасан стандартуудыг хангасан тоног төхөөрөмж сонгосон байх;

11.2.19.Төслийн эрсдлийн удирдлагын менежмент.

11.3. *Эдийн засгийн шинжилгээ тайлан:*

11.3.1. Барилга угсралтын ажлын төсөв;

11.3.2. Ашиглалтын орлого, зардал;

11.3.3. Тарифын шинжилгээ;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 оны 04 дугаар тушаал

11.3.4. Төслийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өнөөгийн үнэ цэнэ, эргэн төлөгдөх хугацаа;

11.3.5. Төслийн өртөг-өгөөжийн дүн шинжилгээ хийх;

11.3.6. Төлөвлөж буй хөнгөн төмөр замын тээврийн хөрөнгө оруулалтын ба эдийн засгийн үр ашгийн шинжилгээ;

11.3.7. Санхүүжилтийн хуваарь, барилгын ажлын үе шат, хөрөнгө оруулалтын үе шат, эдийн засгийн тооцоо судалгааг уялдуулах, Төслийн бараа бүтээгдэхүүний татварын асуудлыг судлах, үнэ чөлөөлөх нөхцөл, эрх зүйн болон эдийн засгийн тооцоолол гарган, дотоодын болон төслийн анхдагч үнийг бууруулах боломжийг судлах.

11.3.8. Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл;

11.3.9. Төлөвлөж буй хөнгөн төмөр замын тээврийн Монгол Улсын болон бүс нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл;

11.3.10. Дэд бүтцийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл;

11.3.11. Бүс, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл;

11.3.12. Хүний хөгжил ба байгаль орчны эрүүл, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл;

11.3.13. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох хөрөнгө оруулалтын төрлыг тодорхойлох.

12. Зураг төслийн иж бүрдэл

12.1. Инженер геодезийн судалгааны ажлын тайлан;

12.2. Инженер геологийн судалгааны ажлын тайлан;

12.3. Ус зүйн судалгааны тайлан;

12.4. Хөнгөн төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төсөл (дэвсгэр, дагуу, хөндлөн огтлолын зургууд, нэг маягийн хөндлөн огтлолыг зургууд, хийцлэлийн зургууд болон бусад шаардлагатай зургууд);

12.5. Хөнгөн төмөр замын хиймэл байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл

12.6. Хөнгөн төмөр замын дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын инженерийн нарийвчилсан зураг төсөл

12.7. Хөнгөн төмөр замын цахилгаанжуулалтын инженерийн нарийвчилсан зураг төсөл

12.8. Хөнгөн төмөр замын удирдлагын төв, депо, зогсоолын барилга болон бусад барилга, байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл

12.9. Тайлбар бичиг;

12.10. Холбогдох бусад инженерийн шугам сүлжээний зургууд;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн даргын 2025 04 дугаар тушаал

12.11. Ажлын нэгдсэн тоо хэмжээ;

12.12. Нэгдсэн төсөв;

12.13. Магадлалын ерөнхий дүгнэлтүүд;

12.14. Техникийн шаардлагууд;

12.15. Барилга угсралтын ажилд шаардлагатай материалуудын техникийн шаардлагууд;

13. Онцгой нөхцөл

13.1. Монгол Улсад төдийгүй ижил төстэй байгаль, цаг уурын нөхцөлтэй хөгжингүй орнуудад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох стандарт, норм, норматив, дүрэм, журмуудыг мөрдөнө.

13.2. Олон улсын бодлогын болон техникийн баримт бичгийг хэрэглэх тохиолдолд урьдчилан захиалагчид албан ёсоор мэдэгдэнэ;

13.3. Хөнгөн төмөр замын тээврийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, үйл ажиллагаа, засвар үйлчилгээний болон бусад холбогдох стандарт, норм, норматив, дүрэм, журмуудыг Монгол улсад нутагшуулах;

13.4. Барилгын материалын сонголт, төрөл харьцуулалт хийх,

13.5. Барилга угсралтын ажлын тендерийн баримт бичгийг боловсруулахад захиалагчид мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;

13.6. Хөнгөн төмөр замын тээврийн шугамын зураг төслийг “Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл-метро”, “Туулын хурдны зам”, “Шинэ их тойруу” хурдны зам, “Улаанбаатар хотын тусгай замын автобус (BRT)” зэрэг бусад дэд бүтцийн төслүүдтэй уялдуулах шийдэл, төлөвлөлт;

13.7. Улаанбаатар хотын болон чигийн дагуу дайран өнгөрч буй суурьшлын бүсүүдийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулах шийдэл, төлөвлөлт;

13.8. Сонгогдсон чигийн дагууд байрлаж буй ногоон байгууламж, дэд бүтцийн байгууламжийг нүүлгэн шилжүүлэх, шинээр барьж, байгуулах шийдэл, төлөвлөлт;

13.9. Төмөр замын чигийг Улсын тусгай хамгаалалттай газрын хориглолт, хязгаарлалтын бүстэй давхцуулахгүйгээр төлөвлөх, зэрлэг ан амьтдын нүүдэл шилжилт хөдөлгөөний нарийвчилсан судалгааг хийж ногоон байгууламж, ан амьтдын гарцын төлөвлөлтийг боловсруулах;

13.10. Хөнгөн төмөр замын тээврийн зам болон хиймэл байгууламжийг элс, цас, үер зэрэг байгалийн үзэгдлээс хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах шийдлийг тусгах;

13.11. Суурьшлын бүсийн хэсэгт орчны дуу чимээ, чичирхийлэлт зэргээс тусгаарлах хамгаалалт болон ногоон байгууламжийн зурвас төлөвлөх;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 04 дүгээр тушаал

13.12. Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх;

13.13. Барилга угсралтын ажлын /талбайн зохион байгуулалтын зураг, график төлөвлөгөө гаргах/ гол бүтээц дам нурууг цутгах угсрах зэрэг талбайн тооцооллыг гаргаж шаардлагатай эдэлбэр газрын тооцоо судалгаа хийх;

13.14. Дээд, доод бүтээц, гүүрэн байгууламжийн хийц бүтээц, өртөө, зогсоол, депо зэрэг барилга байгууламжуудад архитектур төлөвлөлтийн гоо зүй талаас нь онцгой анхаарч төлөвлөх;

13.15. Эрчим хүчний тасалдал үүсэх тохиолдолд авч хэрэгжүүлэх төлөвлөгөө, эрчим хүчний бие даасан 2 дахь эх үүсвэрийн шийдлийг боловсруулах;

13.16. Барилга, байгууламжийн угсралттай холбоотой барилгын материал, нөөцийг тодорхойлсон судалгаа гаргах;

13.17. Барилга, байгууламжийн угсралтын явцад авто замын хөдөлгөөнийг зохицуулах шийдэл;

13.18. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах хугацаанд байгалийн гамшиг, цар тахал гэх мэт давагдашгүй хүчин зүйлс үүссэн тохиолдолд гүйцэтгэгч нь онцгой байдлын үеийн төлөвлөгөө гаргаж ажиллана.

13.1.9 Буудал, зогсоолуудын байгууламж нь цаг агаарын эрс тэс уур амьсгалд дасан зохицсон шийдэлтэй байх

13.20. Зам, тээврийн яам, Хот байгуулалт, барилга, Орон сууцжуулалтын яам, Эрчим хүчний яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төв аймгийн Засаг даргын тамгын газар, Хөшигийн хөндий бүтээн байгуулалтын захиргаа болон бусад харьяа байгууллагууд, Тээврийн цагдаагийн албанаас санал авч тайланд тусгана;

14. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн иж бүрдэл, тайлагнах хэлбэр

14.1. Хөнгөн төмөр зам төлөвлөх, барих, ашиглах, засварлах, норматив баримт бичиг, холбогдох стандартын төслийг боловсруулж батлуулах.

14.2. Төслийн техник эдийн засгийн үндэслэлийн тайланг Зам, тээврийн яамны дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөл, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлүүдийн хурлаар тус тус хэлэлцүүлж холбогдох дүгнэлтийг гаргуулан захиалагчид 2025 оны 05 дугаар сарын 15-нд багтаан дуусгаж захиалагчид хүлээлгэн өгнө

14.3. Тайланг эх хувь монгол, англи хэлээр 1ш, хуулбар 1ш /хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах/ болон тоон хэлбэрээр /*dwg болон *pdf/ хүлээлгэж өгнө. Тоон байдлаар бүх бичиглэлийн материалыг *.doc, *.xls өргөтгөлтэйгөөр Монгол, Англи хэл дээр, зураглалын материалыг *.dwg, *.shp өргөтгөлтэйгөөр баримт бичгийн бүрдлийг *.pdf өргөтгөлтэйгөөр CD болон DVD-ээр хүлээлгэн өгнө. Төслийн

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 оны 04 дугаар тушаал

иж бүрэн хийцлэлийг агуулсан 3D зураг болон дүрс бичлэгийн танилцуулга боловсруулах, төслийн макетыг хийж хүлээлгэн өгөх.

---oOo---

Хянасан:

ТЗУГ-ын дарга Б.Болор-Эрдэнэ

ТЗДТБЗГ-ын дарга Х.Итгэлт

ТЗДТБЗГ-ын шинжээч Ж.Болдхүү

Боловсруулсан:

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн
Төсөл хөтөлбөр, судалгааны
газрын дарга Б.Тамир

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн
Төсөл хөтөлбөр, судалгааны газрын
Замын технологи хариуцсан инженер Э.Ганзориг

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2025 04 дугаар тушаал